НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМ

Олон Улсын Төсвийн Төсөл

Нээлттэй төсвийн санаачлага

2006

# Төр засгийн хариуцлагыг нэмэгдүүлэхэд илүү мэдээлэл шаардлагатай байна


Орчуулагч: Г.БАТБАЯР

Хянан тохиолдуулсан: С.ОДХҮҮ

Н.ДОРЖДАРЬ

Э.СУМЪЯА



Улаанбаатар

2006 он

DDC
352.48
H - 958

Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэх, хувилахыг хүсвэл
**Нээлттэй Нийгэм Форумын** хаягаар хандан зохих зөвшөөрөл авна.

Хаяг:
Жамъян Гүний гудамж - 5/1
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар - 48
Монгол Улс

Утас: 976 - 11 - 313207
Факс: 976 - 11 - 324857

ISBN 978-99929-2-016-5

# ГАРЧИГ

**ӨМНӨХ ҮГ** 4

**ХУРААНГУЙ** 6

**I. ОРШИЛ** 12

Аргачлал 13
Асуулгын боловсруулалт, туршилт 13
Нээлттэй төсвийн асуулгын агуулга 14
Асуулгыг бөглөсөн судлаачид болон шүүмж өгөх үйл явц 16
“Нийтэд ил” мэдээллийн тодорхойлолт 17

**II. НЭЭЛТТЭЙ ТӨСВИЙН ИНДЕКС** 20

**III. ТӨСВИЙН ГОЛ БАРИМТ БИЧГИЙГ НЯГТЛАН ҮЗЭХ НЬ** 23

Боловсруулсан мэдээллийг түгээхгүй байх нь 23
Гүйцэтгэх засаглалын төсвийн санал (төсвийн төсөл) 24
Төсвийн урьдчилсан (хүрээний) мэдэгдэл 26
Жилийн явцын тайлан 27
Хагас жилийн тойм 28
Жилийн эцсийн тайлан 28
Аудиторын тайлан 30

**IV. ОЛОН НИЙТ МЭДЭЭЛЛИЙГ ХҮРТЭХ ЯМАР АРГА ЗАМ БАЙНА ВЭ?** 31
Төсвийн баримт бичгийг интернэтээр дамжуулан хүртэх нь 31
“Мэдээллийг хүртэх эрх”-ийн тухай хууль ба нарийвчлал
бүхий мэдээллийг хүртэх боломж 32

**V. ХУУЛЬ ТОГТООХ БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ** 34

**VI. АУДИТЫН ДЭЭД БАЙГУУЛЛАГЫН ҮҮРЭГ** 40

**VII. ЦААШДЫН АЛХАМУУД** 43

**ХАВСРАЛТ: УЛС ОРОН БҮРИЙН ХУВЬ, ОНОО** 44

# ӨМНӨХ ҮГ

Улс орны хөгжилд төр, засаг чухам ямар үүрэг гүйцэтгэж буйг тодорхойлох бодлогын гол баримт бичиг бол улсын төсөв юм. Иргэд итгэл үзүүлэн, нийгмийн тусын тулд үйл ажиллагаагаа явуулах хөрөнгө мөнгийг татвар хэлбэрээр төр засагт даатгадаг тул тэдний сайн сайхны төлөө ажиллах нь төрийн эрхэм үүрэг билээ. Тийм ч учраас улсын төсвийн талаархи мэдээлэл ил тод байж, олон нийт өөрсдийн хүсэл эрмэлзэл, дуу хоолойг төсөв зохиох, хэрэгжүүлэх, хянах бүхий л үе шатанд хүргэх боломжтой байх нь ардчилсан нийгмийн нэгэн чухал үзүүлэлт байдаг. Энэ бол авилгал, ядуурал, хариуцлагагүй байдал үүсэхээс урьдчилан сэргийлэх гол арга юм.

Нээлттэй Нийгэм Форум төсвийн мэдээллийг ил тод болгох, төсвийн үйл явцад иргэний нийгэм, иргэд бүтээлчээр оролцох боломжийг бүрдүүлэхэд талаар олон талт үйл ажиллагааг байнга хэрэгжүүлж ирлээ. Үүний нэг илрэл нь АНУ-д төвтэй, олон улс оронд үйл ажиллагаагаа явуулдаг “Олон улсын төсвийн төсөл” хэмээх байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн “Нээлттэй Төсвийн Индекс” нэртэй судалгаа юм. Уг индекст нийт 59 улс орон хамрагдаж, төсвийн баримт бичиг иргэддээ хэр нээлттэй байгаад бодит үнэлгээ өгдөг. Энэ удаагийн судалгаа нь Монголын иргэний нийгмийн зүгээс улсын төсөвт хийсэн анхны үнэлгээ болсон юм. Нээлттэй төсвийн индекст Монгол Улсын авсан оноо, эзэлсэн байр хангалтгүй байгааг төр, засаг анхааралдаа авч, иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллаж, манай улсын байр суурийг ахиулах арга хэмжээг богино хугацаанд авч хэрэгжүүлнэ гэдэгт бүрэн итгэлтэй байна.

Судалгааны санааг гаргаж, гардан гүйцэтгэсэн бүх байгууллага, хүмүүст талархал илэрхийлж байна. Юуны өмнө уг судалгааг бэлтгэж, ерөнхийлөн удирдсан Олон улсын төсвийн төсөл, түүний удирдагч Уоррен Крафчик-т талархал илэрхийлье. Та бүхэнд танилцуулж буй энэ судалгааны үр дүнгийн тоймыг орчуулсан Ганын Батбаяр, хянан тохиолдуулсан доктор Сандуйжавын Одхүү нарт талархаж байна.

Судалгааны бүрэн эх материалуудыг ННФ-ын www.forum.mn болон www.openbudgetindex.org вэб хуудсаас авч үзэх боломжтой бөгөөд судалгааны үр дүнгийн талаар аливаа асуулт, санал зөвлөмж гарвал Нээлттэй Нийгэм Форумд хандахыг урьж байна.

“Нарны гэрэл аливаа нянг хамгийн сайн устгадаг”- ийг уншигч Та юу эс андахав. Төр, засгийн бодлого мэргэн, сан хөмрөг арвин, ард түмний аж амьдрал сайн байх болтугай.

П. Эрдэнэжаргал,
Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх Захирал

# ХУРААНГУЙ

Улсын төсвийн мэдээллийг олон нийтэд хүртээмжтэй болгоход дэмжлэг үзүүлэх сонирхол сүүлийн 20-иод жил нэмэгдэж ирлээ. Төр, засагтай хариуцлага тооцдог байхын тулд иргэд төсөв, санхүүгийн үйл ажиллагааг нь авч үзэх боломжтой байх зайлшгүй шаардлагатай гэсэн ойлголтыг энэ сонирхол илэрхийлж байгаа юм. Ийм мэдээллийг тухай бүр нь цаг алдалгүй авснаар өөрсдийн өдөр тутмын амьдралд ихээхэн нөлөөтэй бодлогын шийдвэрүүдийг гаргахад иргэд оролцож, тэдгээрийг ойлгох боломжтой болно.

Уг сонирхол нь мөн дэлхий нийтийн хөгжлийн ерөнхий чиг хандлагыг илэрхийлж байна. 1990-ээд онд олон улс оронд ардчиллын эхлэл, давалгаа хүчээ авснаар авилгалтай тэмцэх, төрийн үр нөлөө бүхий үйлчилгээг хангах, иргэд олон нийт төвтэй хөгжлийг бий болгох зэрэг асуудалд анхаарал төвлөрч ирсэн. Түүнчлэн 1990-ээд онд санхүүгийн ноцтой хор уршиг бүхий хэд хэдэн хямрал үүссэн ба хүндрэлд автсан улс оронд төр засгийн ил тод байдал, санхүүгийн хариуцлага дутагдсанаас учирсан үр дагаварт олон нийтийн хамтын нийгэмлэг анхаарлаа хандуулахад хүрсэн.

Ийм нөхцөлд Олон улсын төсвийн төсөл (ОУТТ) нь 2002 оноос энэхүү судалгааны үндэс болсон асуулгын арга зүйг боловсруулж эхэлсэн. Сүүлийн хоёр жилд ОУТТ 59 улс дахь иргэний нийгмийн болон эрдэм шинжилгээний салбар дахь түншүүдтэйгээ хамтран судалгааг явуулж, үр дүнг нэгтгэн шинжлэх харьцуулсан мэдээллийг цуглуулж ирлээ. Судалгааны аргачлалыг доорхи шигтгээнд тоймлов. Бүх 59 улс орны бүрэн тайланг www.openbudgetindex.org вэб хуудаснаас үзэж болно.

Тус бүр нь олон хариултын сонголттой 122 асуултаас бүрдсэн уг судалгаа нь засгийн газрын төсвийн ил тод байдлын талаар бие даасан, засгийн газрын бус байр суурьнаас үнэлгээ өгч буй анхны судалгаа юм. Судалгаа нь төсвийн жилийн турш төр засгаас бэлтгэх ёстой төсвийн долоон гол баримт бичиг дэх төсвийн олон нийтэд хүртээмжтэй мэдээллийн чанарыг үнэлсэн болно.

Асуулгын ихэнх асуултууд олон талын оролцоотой байгууллагуудаас боловсруулсан удирдамжуудтай ижил төстэй, зарим тохиолдолд тэдгээрээс авч ашигласан болно. Гэхдээ уг асуулга нь эдгээр удирдамжуудаас давж, хууль тогтоогч болон хөндлөнгийн хяналтын байгууллагуудын гүйцэтгэл, бүтэц зэрэгтэй холбоотой асуултуудыг агуулсан болно.

Уг судалгаа нь төр, засгийн санхүүгийн хариуцлагатай байдлыг нэмэгдүүлэх, нийгмийн баялгийн хуваарилалтыг илүү оновчтой болгох асуудлыг хамарч, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах сонирхол бүхий иргэний нийгмийн байгууллагууд, сэтгүүлчид, судлаачид, бодлого боловсруулагчид, эдийн засгийн хөгжлийн асуудлыг судлаач мэргэжилтнүүд зэрэг өргөн хүрээний хэрэглэгчдэд дэмжлэг үзүүлэх зорилготой. Мөн тухайн улсын төр засгийн албан хаагчдад төсвийн гүйцэтгэлээ сайжруулах практик арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд тус дөхөм болох зорилготой.

## Төсвийн мэдээллийн хүртээмжийн талаарх гол үр дүн

Төр засаг иргэдийнхээ өмнө хариуцлага хүлээх явдлыг хангахад төсвийн мөчлөгийн шат бүрт үнэн зөв, цагаа олсон, иж бүрэн мэдээлэл шаардлагатай. Нээлттэй төсвийн индексийн үр дүнгээс харахад судалгаанд хамрагдсан бүх улс орны 90 хувь нь ийм стандартын шаардлагад хүрч ажиллаж чадахгүй байна.

Эл судалгаагаар цөөн тооны засгийн газар сайн оноо авлаа. 59 улсаас зөвхөн зургаа нь буюу Франц, Шинэ Зеланд, Словени, Өмнөд Африк, Их Британи болон АНУ л төсвийн баримт бичигтээ “иж бүрэн” мэдээллийг хангадаг байна.

30 улс оронд төр засаг нь иргэддээ төсвийн талаар “боломжийн” эсвэл “зарим” мэдээллийг өгдөг байна. “Боломжийн” хэмжээний мэдээллээр хангадаг улс орны ангилалд багтсан улсын жишээ нь Ботсвана юм. Хууль тогтоогч байгууллагад хэлэлцүүлэг явагдахаас тодорхой хугацааны өмнө төсвийн хүрээний мэдэгдлийг олон нийтэд зориулан хэвлэн нийтэлснээр уг орны авах оноо нэмэгдэх боломжтой. Мөн үүний нэгэн адилаар Швед улсын хувьд хагас жилийн иж бүрэн тоймыг хэвлэн нийтлэвэл гүйцэтгэл нь ихээхэн сайжрах боломжтой.

Зөвхөн “зарим” мэдээллээр хангадаг улс орны авсан үнэлгээнд хууль тогтоогч болон олон нийтэд хүргэж буй мэдээлэлд тогтолцооны шинжтэй дутагдлууд байгаа нь сөргөөр нөлөөлж байна. Иордан, Казахстан, Кени зэрэг улс орон энэ ангилалд хамаарч байна.

Хамгийн их анхаарал татаж буй улс орон нь төсвийн талаар иргэдээ “багахан мэдээллээр хангадаг”, мөн “хангалтгүй мэдээллээр хангадаг, эсвэл мэдээллээр огт хангадаггүй” ангилалд багтаж буй 23 улс юм (судлагаанд хамрагдсан бүх улс орны 39 хувь). Энэ хоёр ангилалд багтаж буй улс орнууд төсвийн нээлттэй байдлын хамгийн энгийн шаардлагуудыг ч хангаж чадахгүй байна.

Хамгийн доод ангилалд 10 улс орон багтаж байгаа нь Ангол, Болив, Буркина Фасо, Чад, Египт, Монгол, Морокко, Никарагуа, Нигери болон Вьетнам юм. Эдгээрийн зургаад нь хууль тогтоогч байгууллага төсвийг хэлэлцэж батлахаас өмнө гүйцэтгэх засаглалын төсвийн саналыг олон нийтэд хүргэдэггүй нь төсвийн үйл явц хаалттай, олон нийтийн өмнө хариуцлага хүлээх явдал дутагдалтай байгааг харуулж байна. Никарагуа, Болив гэсэн хоёр улсын хувьд батлагдахаас нь өмнө төсвийн төслийг олон нийтэд хүргэдэг ч энэ нь тун чамлахаар хэмжээний мэдээлэл байдаг байна.

Индексээс дүгнэхэд төсвийн ил тод байдлыг хангах туршлагыг хөгжингүй, хөгжиж буй улс орнууд аль нь ч хэрэгжүүлэх боломжтой байна. Тухайлбал, Словени, Өмнөд Африк улсууд харьцангуй богино хугацаанд төсвийн ил тод байдлаа эрс сайжруулсан байна.

Гэвч төсвийн ил тод байдлын хувьд ихэнх улс орон нэн хангалтгүй гүйцэтгэлтэй байгааг харуулсан асуулгын ерөнхий үр дүн санаа ихээхэн зовоож байна. Судалгаанд хамрагдсан улс орны гуравны нэгээс илүү нь иргэдээ төсвийн талаарх багахан мэдээллээр хангадаг буюу огт мэдээлэл өгдөггүй байна. Ийм улс орны тоонд бага болон дунд хэмжээний орлого бүхий Африк, Ази, Латин Америк, Ойрхи Дорнодын янз бүрийн улс орнууд орж байна.

Тодорхой байгаа нэг зүйл бол тухайн улсын төсвийн ил тод байдлын түвшинд төр засгийн иргэдийнхээ өмнө хариуцлага хүлээх хүсэл эрмэлзэл ихээхэн нөлөөлж байна. Харин мэдээллийг бэлтгэх чадавхи дутагдах нь чухал хүчин зүйл биш ажээ. Өөрөөр хэлбэл, Нээлттэй Төсвийн Индексийн хүрээнд хамгийн тааруу гүйцэтгэлтэй улс орнууд нь чадавхи дутагдсаныг шалтаг болгох үндэслэлгүй ба багахан нөөц хөрөнгөөр богино хугацаанд ил тод байдлыг эрс нэмэгдүүлэх бүрэн боломжтой юм.

## Төсвийн тогтолцоонд шаардлагатай хяналт, тэнцвэртэй байдал олон тохиолдолд дутагдаж байна

Төр засгийн хариуцлага хүлээх явдлыг хангах үүднээс төсвийн үйл явцад суулгаж өгсөн механизмуудтай холбоотой асуулгын үр дүн мөн анхаарал татаж байна. Асуулгын хариултуудаас харахад олон улс оронд төсвийн төсөлд иргэдийг оролцуулах, тэднийг мэдээллээр хангах боломжуудыг бүрэн ашиглахад гүйцэтгэх засаглал болон хууль тогтоох байгууллагын аль аль нь хариуцлагатай хандахгүй байна. Төсвийн талаар олон нийтийн хэлэлцүүлгийг олон улс оронд хийдэггүй байна. Тухайлбал, судалгаанд хамрагдсан 59 улсын 24 нь төсвийн макроэдийн засгийн үзүүлэлтүүдийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулаагүй байхад мөн адил тооны (25) улс орон тодорхой яам, агентлагын төсвийн талаар ийм хэлэлцүүлгийг бас хийгээгүй байна.

Мөн судлагдсан улс орнуудад бие даасан хөндлөнгийн аудитын байгууллагууд түгээмэл доголдолтой нь судалгаанаас харагдаж байна. Аудитын бие даасан, хүчтэй төв байгууллага (зарим улс оронд ерөнхий аудитор, мөн данс бүртгэлийн шүүх ч гэж нэрлэдэг) үгүй бол гүйцэтгэх засаглалын санхүүгийн менежментийг хөндлөнгөөс нягтлан

шалгах асуудал байхгүй гэсэн үг. Олон улс оронд (17) аудитын тайланг олон нийтэд зориулж огт нийтэлдэггүй нь ихээхэн анхаарал татаж байна. 25 улс оронд олон нийтэд зөвхөн хэсэгчилсэн мэдээлэл л очдог байна. Мөн 16 улсад гүйцэтгэх засаглал нь хууль тогтоох, эсвэл шүүх засаглалтай зөвшилцөлгүйгээр тухайн улсын аудитын байгууллагын тэргүүнийг ажлаас нь чөлөөлөх эрхтэй байна. Үндэсний аудитын байгууллагын даргад ажил үүргээ тогтвортой гүйцэтгэх боломж олгохгүй байгаа нь гүйцэтгэх засаглалаас уг байгууллагын хараат бусаар үйл ажиллагаагаа явуулах баталгаа дутагдаж байгааг харуулж байна.

## Иргэдийн мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх нь

Судалгаанд хамрагдсан улс орны талаас илүү хувийн (32) төр засаг нь өөрсдийн дотоод хэрэгцээнд болон хандивлагчдад зориулан бэлтгэн гаргадаг мэдээллээ олон нийтэд хүргэдэггүй байна. Тиймээс бэлтгэн гаргадаг мэдээллээ олон нийтэд хүргэдэг болсноор олон улс орон өөрсдийн ил тод байдал, хариуцлага хүлээх байдлаа эрс сайжруулах боломжтой юм. Мөн төр засаг олон нийтэд мэдээлэл хүргэхгүй байх нь түүнийг бэлтгэх чадвар, хөрөнгө мөнгө байхгүйдээ бус, гол нь мэдээллийг өөртөө нууцлан үлдэж байгаатай холбоотой болохыг нотолж байна.

Судалгаанд хамрагдсан олон улс орон олон нийтэд төсвийн баримт бичгийг хүргэхдээ интернэтийг ашиглаж байгаа нь нааштай туршлага юм. Интернэтийг ашиглах нь төр засгийн хувьд төсвийн баримт бичгийг сонирхсон бүх талуудад нэгэн зэрэг хүргэх, зардал багатай зэрэг давуу талтай арга юм. Гэхдээ интернэтийн гарцгүй хүмүүст зориулан төсвийн мэдээллийг хүргэх талаар төр засаг өөр ажил хийх боломжтой юм.

Бага орлоготой олон улс орны иргэдийн ихээхэн хэсэг нь интернэтийг хүртэхгүй байгаа тухай иргэний нийгмийн байгууллагууд онцлон тэмдэглэж байсан. Тэдний үзэж буйгаар, мэргэжлийн бус хүн ч ойлгох боломжтой хэлбэрээр төсвийг тайлбарласан “иргэдийн төсөв”-ийг бэлтгэх зэрэг хэлбэрээр төсвийн мэдээллээр иргэдийг хангах бусад арга хэмжээнүүдийг төр, засгаас авах шаардлагатай байна. Судалгаанаас харахад тун цөөхөн буюу 59 улсаас ердөө 10 нь л иргэдэд зориулсан ийм төсвийн баримт бичгийг бэлтгэдэг байна.

**Нээлттэй Төсвийн Асуулга**

*Нээлттэй төсвийн индекс*-ийг Нээлттэй төсвийн асуулгын 91 асуултад өгсөн хариултын дунджийг ашиглан тооцож гаргасан. Энэхүү 91 асуулт нь төсвийн долоон гол баримт бичиг дэх төсвийн талаарх мэдээлэл олон нийтэд хүртээмжтэй байдлыг судалж байгаа. Асуулгад төсвийн үйл явц болон санхүүгийн удирдлагад төрөөс хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн төр засгаас хэрэгжүүлж болох төрөл бүрийн арга хэмжээг үнэлэх зорилгоор 31 асуулт нэмж оруулсан болно.

Уг судалгааны ажил нь хамрагдсан улс орнууд дахь төсвийн ил тод байдалд бие даасан, төрөөс хараат бус үнэлгээг өгөх зорилготой. Нээлттэй төсвийн асуулгыг бөглөсөн бүх хүмүүс нь эрдэм шинжилгээний болон төрийн бус байгууллагын ажилтнууд байв. Асуултууд нь засгийн газраас олон нийтэд хүртээмжтэйгээр гаргасан мэдээлэлд үнэлгээ өгсөн бөгөөд орон нутгийн түвшинд байгаа мэдээллийг авч үзээгүй болно.

Асуултуудыг боловсруулахдаа төсвийн ил тод байдлын талаарх хуулийн зүйл заалтуудыг бус, хялбархан ажиглаж болох үйл явдлыг тусгах зорилго агуулсан болно. Төсвийн долоон гол баримт бичгийн агуулга, цаг хугацааны тохиромжтой байдалд төвлөрсөн асуултууд нь төрийн санхүүгийн менежментийн нийтээр хүлээн зөвшөөрсөн тэргүүн туршлага дээр үндэслэсэн шалгууруудыг ашигласан. Эдгээрийн ихэнх нь олон талын оролцоот байгууллагуудаас боловсруулсан шалгууруудыг тусган, тэдгээрт үндэслэсэн билээ. Тухайлбал Олон улсын валютын сангийн Төсвийн ил тод байдлын сайн туршлагуудын код, НҮБ-ын Аудитын дээд институтуудын олон улсын байгууллага (INTOSAI)-аас
гаргасан Аудитын дүрмүүдийн удирдамжийн талаарх Лима-ийн тунхаглал зэргийг ашигласан болно.

ОУВС-ийн Төсвийн ил тод байдлын код, Лимагийн тунхаглал зэрэг баримт бичгүүдийн давуу тал нь тухайн улс орны төсвийн тогтолцооны болон орлогын түвшний ялгаа зэргээс үл хамааран дэлхий нийтээр хэрэглэх боломжтойд оршино. Гэхдээ төсөвлөлт нь иргэдийн хэрэгцээ шаардлагыг хангасан, тэдний өмнө хариуцлага хүлээх боломжийг бүрдүүлэхийн хувьд эдгээр баримт бичиг хангалтгүй юм. Тиймээс ч нээлттэй төсвийн асуулгад иргэний нийгмийн хувьд ач холбогдол бүхий нэмэлт сэдвүүдийг хамруулсан. Жишээ нь, асуулгад хууль тогтоох байгууллага олон нийтийн сонсгол хэлэлцүүлэг хийдэг эсэх, мөн төрийн аудитын байгууллагын гүйцэтгэл, бүрдүүлэлтийг үнэлсэн асуултуудыг оруулсан болно.

Олон улсад иргэний нийгмийн байгууллагуудын анхаарал сонирхлыг илүүтэйгээр татаж буй асуудал бол “мэдээллийг хүртэх эрх”-ийн тухай хуулиуд юм. Үйлчилгээг хүргэх явдлыг сайжруулах асуудалд анхаарал илүү төвлөрч байгаа нь иргэдээс нарийвчлал бүхий, тухайлбал, тухайн орон нутгийн сургууль, эсвэл эрүүл мэндийн төвийн төсвийн зарцуулалтын мэдээлэл хүртэх сонирхолыг нэмэгдүүлж байна. Харин ийм зүйлчилж нарийвчилсан мэдээлэл улс орны төсвийн баримт бичигт гол төлөв тусдаггүй. Тиймээс мэдээлэл хүртэх эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх нь олон улс орны хувьд бодит амьдралд иргэдээс ийм төрлийн мэдээллийг хүртэх боломжийг нэмэгдүүлэх анхны бөгөөд суурь алхам байх болно.

ОУТТ уг индексийг хоёр жил тутамд нийтлэхээр төлөвлөж байгаа ба цаашид илүү олон улс орныг шинээр хамруулж, цаг хугацаа өнгөрөх тутам төр засгийн төсвийн ил тод байдалд гарч буй өөрчлөлтийг тусгахыг зорих болно.

# I. ОРШИЛ

Иргэний нийгмийн хувьд харьцуулсан судалгааны аргаар дамжуулан төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх сонирхол нь дэлхий нийтийн хэд хэдэн чухал чиг хандлагаас үүдэлтэй. Үүнд 1990-ээд онд олон улс оронд үүссэн ардчиллын давалгаа нь авилгатай тэмцэх, төрийн үйлчилгээ үзүүлэхэд хариуцлага тооцох тогтолцоог бүрдүүлэх, төр засгийн төвлөрлийг сааруулах, олон нийт манлайлсан хөгжлийг хангах зэрэгт анхаарлыг төвлөрүүлсэн чиг хандлагыг бий болгосон юм. Түүнчлэн, 1990-ээд онуудад үүссэн хэд хэдэн удаагийн санхүүгийн хямрал нь төр засгийн ил тод байдал, санхүүгийн хариуцлага хүлээх явдлын ач холбогдолд олон улсын санхүүгийн байгууллагууд анхаарлаа хандуулахад хүргэсэн.

Нээлттэй төсвийн төсөл нь эдгээр үйл явдлын ач холбогдлыг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр төсвийн ил тод байдлыг бие даасан байр сууринаас нягтлан шалгах зорилгоор асуулгын аргачлал, хэрэгслүүдийг боловсруулж эхэлсэн. Эдгээр аргачлал, хэрэгслүүд нь Нээлттэй төсвийн индексийн суурийг бүрдүүлэв. Сүүлийн хоёр жилийн хугацаанд ОУТТ нь 59 улс орон дахь хамтрагчдын хүчээр энэхүү асуулгыг ашиглан мэдээлэл цуглуулж, Нээлттэй төсвийн индексийн 2006 оны үр дүнг боловсруулан гаргалаа.

Энэхүү судалгаа нь иргэний нийгмийн байгууллагууд, сэтгүүлчид, судлаачид, эдийн засгийн хөгжлийг судлаач мэргэжилтнүүд, төрийн салбар дахь санхүүгийн хариуцлага тооцох тогтолцоог сайжруулах зорилго бүхий нөлөөллийн үйл ажиллагаа явуулахад нь тус дэм үзүүлэх зорилготой юм. Ингэснээр ард түмний амьдралд бодит ахиц дэвшил гарах боломжтой юм. Мөн тухайн улсын төр засгийн албан хаагчид, бодлого боловсруулагчид төсвийн ил тод байдал, хариуцлага хүлээх тогтолцоогоо сайжруулах практик арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэхэд тус дөхөм болох зорилготой.

## Аргачлал

ОУТТ-өөс гурван жилийн хугацаанд боловсруулсан Нээлттэй төсвийн асуулга нь олон нийтэд хүртээмжтэй төсвийн мэдээлэл, төсөвлөлт дэх хариуцлага тооцох туршлагын харьцуулсан мэдээ, өгөгдөл цуглуулах зорилготой. Асуулга нь судлаачид төсвийн дөрвөн үе шат бүрийг судлан, шат бүрээс олон нийтэд хүргэх ёстой мэдээлэлд үнэлгээ дүгнэлт өгөхөд нь тус дэм болох зорилготой. Мөн жилийн төсвийн үе шат бүрт төсөвлөлт дэх хариуцлага тооцох туршлагыг илрүүлж, үнэлэлт дүгнэлт өгөхөд чиглэсэн.

Нээлттэй төсвийн асуулга нь нийт 122 асуулттай. Эдгээрээс төсвийн мэдээллийн хүртээмжийг үнэлсэн 91-т нь өгсөн хариултыг дундажлаж, Нээлттэй төсвийн индексийг тооцсон болно. Үлдсэн 31 асуулт нь төрийн гол институциудээс гүйцэтгэх засаглалтай хариуцлага тооцох боломж, чадвартай холбоотой сэдвийг авч үзжээ. Тиймээс асуулга нь ерөнхийдөө төсвийн хэлэлцүүлэг, мэтгэлцээнд иргэдийн оролцох боломж, мөн хууль тогтоох байгууллагын хяналтыг нэмэгдүүлэхийг урамшуулах асуудлыг хөндөж байна. Хариуцлагатай төсөвлөлт нь гүйцэтгэх засаглалаас хараат бус, бие даасан аудитын хүчтэй байгууллага байхад хэрэгжинэ. Тиймээс асуулгад тухайн улс орны хөндлөнгийн аудитын байгууллага буюу аудитын дээд байгууллагатай холбоотой институциин чухал асуудлуудыг хөндсөн болно.

## Асуулгын боловсруулалт, туршилт

1999 онд төсвийн ил тод байдлын судалгааг хэрэгжүүлэх арга зүйг ОУТТ ба Өмнөд Африкийн Ардчиллын төлөө хүрээлэн (ИДАСА) хамтран боловсруулж туршсан. 2002 онд гэхэд төсвийн ил тод байдлын судалгааны иргэний нийгмийн хоёр санаачлага Африк болон Латин Америкт хэрэгжиж байсан. Эдгээрийг Африкт ИДАСА, харин Латин Америкт Мексикийн Судалгаа, шинжилгээний Фундар төв удирдаж байсан. Уг асуулгыг боловсруулахад энэ хоёр санаачлага ихээхэн хувь нэмэр оруулсан юм. Энэ хоёр санаачлагад хамрагдсан улс орны судлаачид уг асуулгыг турших, асуултуудыг боловсронгуй болгоход үнэтэй санал зөвлөмж өгсөн болно.

ОУТТ мөн 2003 онд асуулгын арга зүй, хэрэгслийн анхны хувилбараа дээрх бүс нутгаас гадна арван улс (Болгар, Хорвати, Чех, Энэтхэг, Казахстан, Польш, ОХУ, Словени, Тайланд, Турк)-д туршсан. ОУТТ энэхүү туршилтын дүнг ашиглан асуултуудыг өөрчилж, төсөвлөлтийн ялгаа бүхий тогтолцоотой улс оронд ч хэрэглэх боломжтой болгосон. Мөн судлаачдаас өгсөн зөвлөмжүүд нь "Нээлттэй төсвийн асуулгын удирдамж"-ийг ОУТТ бэлтгэхэд ихээхэн тус нэмэр болсон. Энэхүү удирдамж нь асуулгыг бөглөж буй судлаачдад асуулт бүрийн зорилго, хариултыг сонгоход ашиглах нөхцлүүдийг нарийвчлан тайлбарласан.

Мөн дэлхийн өнцөг булан бүрийн төсвийн зарцуулалтын менежментийн шинжээчидтэй зөвлөлдсөний үндсэн дээр асуулгыг 2003 оны сүүлийн хагаст улам боловсронгуй болгосон. Үүнд мэргэжлийн сэтгүүлд нийтлэл хэвлүүлэх замаар олон улсын санхүүгийн байгууллагууд болон практик туршлагатай хүмүүсийн саналыг авсан болно. Туршилтын хоёрдахь буюу үндсэн үе шатыг 36 улс орон дахь судлаачдыг оролцуулан зохион байгуулсан. Судалгааны ажлыг 2004 оны 5, 6 дугаар сард багтаан дуусгасан. Уг туршилтын үе шатны үр дүнг 2004 оны 10 дугаар сард нийтэд хүргэснээр асуулгыг болон дагалдах удирдамжийг улам бүр боловсронгуй болнох зорилготойгоор хариу санал зөвлөмж цуглуулсан.

### Нээлттэй төсвийн санаачлагын зөвлөх хороо

Уг төслийн хүрээнд төсвийн ил тод байдлыг хөхүүлэн дэмжих үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн манлайлагч байгууллагуудын төлөөлөгч болон төсвийн зарцуулалтын удирдлагын чиглэлээр хүлээн зөвшөөрөгдсөн шинжээчдийг хамруулсан зөвлөх бүлэг ажилласан. Үүнд:

**Хелена Хофбауэр**, гүйцэтгэх захирал, Мексикийн Судалгаа, шинжилгээний Фундар төв

**Катарина Отт**, гүйцэтгэх захирал, Хорватийн Төрийн санхүүгийн хүрээлэн

**Маррит Клаасэнс**, менежер, Африкийн төсвийн төсөл, Өмнөд Африк дахь Ардчиллын төлөө хүрээлэн

**Давид дэ Фэрранти**, захирал, Ил тод байдал, хариуцлагын тогтолцоо, Брукинг хүрээлэн

**Муррэй Пэтри, захирал**, Шинэ Зеландын Транспарэнси Интернэшнл

**Малколм Холмс**, төсвийн зарцуулалтын менежментийн олон улсын шинжээч

**Ирис Лоу**, дэд захирал, Төсөв, бодлогын асуудлуудын төвийн дэд захирал

**Исаак Шапиро**, захирал, Төсөв, бодлогын асуудлуудын төвийн дэд захирал

**Жоэл Фридман**, ахлах судлаач, Төсөв, бодлогын асуудлуудын төвийн дэд захирал

## Нээлттэй төсвийн асуулгын агуулга

Нээлттэй төсвийн асуулга нь олон хариултаас сонгох боломж бүхий асуултууд, мөн төсвийн мэдээллийг түгээх хэлбэрийг харуулсан дөрвөн хүснэгтээс бүрдсэн. Асуулгад орсон асуултуудыг гурван хэсэгт хуваасан болно. Эхний хэсэгт төсвийн мэдээлэл түгээлтийг хамарсан хүснэгтүүд орсон. Хоёрдугаар хэсэгт хууль тогтоох байгууллагад өргөн барьдаг гүйцэтгэх засаглалын жил тутмын төсвийн төсөл (1-55-р асуулт) болон төсвийн бодлого, хэрэгжилтэд дүн шинжилгээ хийхэд тустай бусад мэдээллийг авах боломж (56-66-р асуулт)-ийн талаарх асуултуудыг агуулж байгаа. Гуравдугаар хэсэгт төсвийн үйл явцын дөрвөн үе шат тус бүрийг авч үзсэн болно (67-122-р асуулт).

Асуултууд нь төв засгийн газрын зүгээс олон нийтэд хүргэж буй мэдээллийг үнэлсэн бөгөөд орон нутгийн төр, засгийн түвшин дэх мэдээллийн хүртээмжийн асуудлыг хамраагүй юм. Ихэнх асуулт нь хуулийн шаардлага ямар байгаа тухай бус, бодит амьдралд гарч буй туршлагын асуудлыг хөндсөн. Бүх асуултыг боловсруулахдаа хялбархан ажиглаж болох үзэгдлийг хамрах зорилтыг дэвшүүлсэн. Судлаачид, шүүмжлэгчдэд хандан өгсөн хариултдаа нотолгоо гаргахыг хүссэн. Нотолгоо нь төсвийн баримт бичиг, хууль, олон нийтэд ил бусад баримт бичгийн заалт, төр засгийн албан тушаалтны олон нийтэд зориулж хийсэн мэдэгдэл, төрийн албан тушаалтан, эрх бүхий бүхий талтай хийсэн ганцаарчилсан уулзалтыг ишлэх хэлбэртэй байсан.

Асуултууд нь төр засгаас нийтлэж буй мэдээллийн чанар, үнэн зөв байдалд үнэлгээ өгөхийг зориогүй. Жишээлбэл, засгийн газрын зарцуулалт, орлого, өр төлбөрийн талаарх мэдээллийг төр засгийн данс тайлангаас хууль бус байдлаар орхигдуулсан, оруулаагүй, шилжүүлсэн байдалд асуултууд ямар нэгэн үнэлгээ өгөхгүй. Мөн улсын төсвийн тооцоог гаргахад ашигласан макро эдийн засгийн таамаглал, эдийн засгийн суурь нөхцлүүд үнэн бодитой эсэхэд асуултууд ямар нэгэн үнэлгээ өгөхийг зориогүй.

Ихэнх асуулт нь бүх улс оронд боловсруулан гаргах ёстой төсвийн долоон гол баримт бичгийн агуулга, цаг хугацааны оновчтой байдалд төвлөрөн чиглэсэн болно. Ямар мэдээлэл олон нийтэд ил байх, мэдээллийг нийтлэх шаардлагатай цаг хугацааг үнэлэхэд ашигласан шалгуурууд нь төрийн санхүүгийн менежменттэй холбоотой нийтээр хүлээн зөвшөөрсөн сайн туршлагууд дээр үндэслэсэн. Эдгээр шалгуурын ихэнх нь Олон улсын валютын сангийн Төсвийн ил тод байдлын тэргүүн туршлагын код болон НҮБ-ын Аудитын дээд институтуудын олон улсын байгууллага (INTOSAI)-аас эрхлэн гаргасан Аудитын дүрмийн удирдамжийн талаарх Лимагийн тунхаглал зэрэг олон талт байгууллагуудын боловсруулсан шалгуур стандартуудтай ижил төстэй. INTOSAI нь төрийн секторын аудиттай холбоотой мэдээлэл, туршлага солилцох зорилгоор НҮБ-ээс байгуулагдсан үндэсний аудитын дээд байгууллагуудын мэргэжлийн байгууллага юм.

ОУВС-ийн Төсвийн ил тод байдлын код болон Лимагийн тунхаглал зэрэг удирдамж баримт бичгийн давуу тал нь эдгээрийг дэлхий нийтээр хэрэглэх боложтой байдагт оршино. Тиймээс эдгээр нь дэлхий даяар төсвийн тогтолцоо нь ялгаатай, мөн орлогын хувьд ялгаатай улс оронд ч аль алинд нь хамаатай байдаг. Гэвч ОУТТ-ийн үзэж байгаагаар төсөвлөлт иргэдийнхээ хүсэл эрмэлзлийг тусгасан, тэдний өмнө хариуцлага хүлээх тогтолцоог бүрдүүлсэн байх талаасаа эдгээр баримт бичиг нь бас хангалтгүй юм. Энэ шалтгааны улмаас Нээлттэй төсвийн асуулгад иргэний нийгмийн хувьд чухал нэмэлт сэдвүүдийг оруулж өгсөн. Үүнд хууль тогтоох байгууллага нь төсвийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулдаг эсэх, мөн хууль тогтоох байгууллагын хяналт, аудитын дээд байгууллагатай холбоотой бусад хүчин зүйлийг тусгасан болно.

## Асуулгыг бөглөсөн судлаачид болон шүүмж өгөх үйл явц

Нээлттэй төсвийн асуулга нь судалгаанд хамарсан улс орнууд дахь төсвийн ил тод байдлыг бие даасан, төрийн бус байр сууринаас үнэлэх зорилготой. Нээлттэй төсвийн асуулгыг бөглөсөн бүх хүмүүс нь эрдэм шинжилгээний, эсвэл төрийн бус байгууллагыг төлөөлсөн болно. Судалгааг авсан 59 улс оронд төрийн албан тушаалтнууд асуулгыг бөглөөгүй ч зарим тохиолдолд асуултад хариулах зорилгоор судлаачид тэдэнтэй ярилцлага хийсэн.

Судалгаанд оролцсон бүлгүүдийн чиг үүрэг, сонирхдог асуудлууд ихээхэн ялгаатай ч төсвийн үйл явцын дөрвөн үе шат тус бүр дэх мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлэх, хууль тогтоох байгууллагын үүрэг, эрх мэдлийг бэхжүүлэх, аудитын дээд байгууллагын гүйцэтгэлийг сайжруулах нийтлэг сонирхолтой юм. Ихэнх бүлгүүд нь төсвийн асуудалд ихээхэн анхаарч ажилдаг ба өдөр тутам төсвийн асуудалд оролцдог шинжээчдийг ч судлаачаар ажиллуулжээ.

Улс тус бүрээс нэг судлаач, эсвэл нэг байгууллагын судлаачдын баг тухайн улсынхаа гүйцэтгэлийг танилцуулсан асуулгыг бэлтгэсэн болно. Тиймээс судалгааны дүн нь нэг л бөглөсөн асуулга дээр үндэслэсэн. Судлаачид өөрсдийн судалгааг 2005 оны 5-р сард эхлэж, 2005 оны 10-р сард дуусгасан юм. 2005 оны 10-р сараас хойш болсон үйл явц, өөрчлөлтийг судалгаанд тусгаагүй болно. Дээр дурьдсанчлан, асуулгыг бөглөсөн судлаачид, мөн шүүмж өгөгчид өөрсдийн хариултынхаа нотолгоог гаргаж өгсөн юм.

Асуулгыг бөглөж дууссаны дараа ОУТТ-ийн ажилтнууд асуулга тус бүрт дүн шинжилгээ хийж, асуулгыг нягтлан судлаачидтай ихэнхдээ 3-6 сарын турш харилцан ярилцаж байсан. ОУТТ-ийн хийсэн дүн шинжилгээ нь асуултад агуулга талаас оновчтой хариулсан байх, бусад улстай харьцуулахад жигд хариулсан байхад анхаарсан байна. Мөн хариултуудыг олон нийтэд ил тод байгаа мэдээлэлтэй харьцуулан шалгасан. Үүнд улс орнуудаас интернэт дээр байрлуулсан төсвийн баримт бичиг, банкны мэдээллийн төв (Вашингтон хотод төвтэй, олон улсын санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд мониторинг хийдэг ашгийн төлөө бус байгууллага)-өөс цуглуулсан өгөгдөл, ОУВС-ийн Стандарт, кодыг биелүүлж байгаа талаарх тайлангуудын төсвийн ил тод байдлын асуудалд хамаатай хэсгүүд, ОУВС-ийн "4-р зүйл"-ийн тайлангууд, Дэлхийн Банкны удирдамж баримт бичиг, нийтлэлүүд (төсвийн зарцуулалтын тойм г.м.), ЭЗХАХБ-Дэлхийн Банкны төсвийн үйл ажиллагааны өгөгдлийн сан зэрэг мэдээллийг ашигласан болно.

ОУТТ судлаачдын баримтлах Нээлттэй төсвийн асуулгын удирдамжаар хангасан. Уг удирдамж нь асуулгыг бөглөхөд анхаарах судалгааны арга зүйг тоймлож, төсвийн ил тод байдал, төсвийн зарцуулалтын менежментийн шилдэг тушлага, ухагдахуунуудын талаар судлаачдад танилцуулга өгөхөд чиглэгдсэн юм. Мөн удирдамжид хариултуудаас сонголтыг яаж хийх, асуулт тус бүрт хариулахад ямар угтвар нөхцлүүдийг ашиглах талаар нарийвчилсан тайлбар өгсөн болно.

Асуулга тус бүрийг ОУТТ нягтлан үзсэний дараагаар нэрийг нь нууцалсан хоёр судлаачдад өгч шүүмж авсан. Төр засаг, судалгааны байгууллага аль алинаас нь хараат бус байх шаардлага шүүмжлэгчдэд тавигдсан. Шүүмжлэгчид тухайн улсын болон төсвийн тогтолцооны нь талаар илүү нарийн мэдээлэл, мэдлэгтэй хүмүүс байсан. Ном зүйд нэр нь дурьдагдсан байдал, хувийн харилцаа, интернэтийн хайлт, ОУТТ-ийн бусад уулзалтад оролцогсдын жагсаалт зэрэгт түшиглэн тэднийг тодруулсан болно. ОУТТ шүүмж өгөх тогтолцоог нууц байх ёстой гэж үзэж, олон нийт болон судалгааны байгууллагад шүүмжлэгчийн хэн болохыг хэлээгүй юм.

ОУТТ-ийн ажилтнуудаас Нээлттэй төсвийн асуулгын удирдамжид тусгагдсан судалгааны арга зүйтэй шүүмжлэгчдийн санал зөвлөмж нийцэж байгаа эсэхийг нягтлан үзсэн. Удирдамжтай зөрчилдөж буй шүүмжлэгчийн аливаа санал зөвлөмжийг хасч, үлдсэнийг нь судлаачдад танилцуулсан. Судлаачид шүүмжлэгчдийн санал зөвлөмжид хариу өгч, ОУТТ-ийн редакторууд аливаа санал зөрөлдөөнтэй хариултуудыг эцэслэн шүүж, улмаар хариултыг сонгоход бүх улс орон нэгэн жигд нөхцлүүдийг ашиглах явдлыг хангасан болно.

## “Нийтэд ил” мэдээллийн тодорхойлолт

Нээлттэй төсвийн асуулгын анхаарлын төвд олон нийтэд ил тод, хүртээмжтэй мэдээлэлд үнэлгээ өгөх явдал байсан. Тиймээс уг судалгаанд “нийтэд ил” мэдээллийг *“тухайн баримт бичгийг гаргаж буй төрийн эрх бүхий байгууллагад хүсэлт тавих замаар аливаа иргэн, бүх иргэд авч болох мэдээлэл”* гэж тодорхойлсон. Энэ тодорхойлолтод заасан мэдээлэл нь төрийн баримт бичгүүдийг сонирхсон бүх талууд зэрэг авах боломжийг хангасан сайтар боловсруулсан дүрэм журмын дагуу авдаг мэдээлэл, зөвхөн хүсэлт тавьж авч болох мэдээлэл болон баримт бичиг аль алиныг нь хамарч байна.

Судалгаанд хамрагдсан улс орны зарим нь сонирхсон бүх талуудад төрийн баримт бичгийг нэг зэрэг ил болгох явдлыг хангах тодорхой дүрэм журамтай байна. Хуулинд төсвийн баримт бичгийг түгээх тодорхой дүрэм журмыг тусгаж, эдгээр дүрэм журмыг амьдралд хүндэтгэн хэрэгжүүлэх нь зарим улс орны хувьд санхүүгийн сайн менежмент бүхий улс гэх олон улсын нэр хүндийг хадгалахтай адил нэн чухал байдаг. Олон улсын хөрөнгийн зах зээлд гарц хайсан, уг зах зээлийн зүгээс таатай хандлагыг хадгалахыг хүссэн хөгжиж буй улс орнууд ийм дүрэм журмыг бие даан, эсвэл ОУВС-ийн Мэдээлэл түгээх ерөнхий тогтолцоо зэрэг санаачлагад оролцогчийн хувьд хэрэгжүүлдэг.

Судалгаанд хамрагдсан олон улс оронд төсвийн мэдээллийг түгээн тараахтай холбогдсон хуулийн зохицуулалт байхгүй, эсвэл ийм зохицуулалтыг амьдралд хэрэгжүүлэхгүй байна. Ийм улс оронд мэдээллийг зөвхөн хүсэлт гаргаж авах боломжтой. Эдгээр улс оронд судалгаа хийсэн хүмүүс асуултуудыг зөвхөн олон нийтэд ил байгаа мэдээлэлд үндэслэж хариулжээ. Зарим тохиолдолд судалгааны багууд төсвийн баримт бичгийг олж үзэх оролдлого хийхийг иргэдээс хүсдэг. Ингэснээр мэдээлэл өргөн олон нийтэд хүртээмжтэй эсэхийг турших үзэж байсан. Зарим улс оронд төсвийн тухай ихээхэн мэдээлэл

боловсруулагддаг ч түүнийгээ олон нийттэй огт хуваалцдаггүй, төрийн албан хаагчид мэдээллээ хэнтэй хуваалцах боломжтойгоо өөрсдөө шийддэг учир ийм арга хэмжээ авах шаардлагатай болсон юм. Мэдээллийг зөвхөн хүсэлт гарган олж авах боломжтой тохиолдолд ийм хүсэлт гаргасан хүнд мэдээлэл өгөхөөс татгалзсан бол уг баримт бичгийг олон нийтэд ил биш байна гэж судалгааны зорилгын хүрээнд үзсэн болно.

Судалгаанд ашигласан “нийтэд ил” мэдээллийн тодорхойлолтоос харахад баримт бичгийг түгээх арга зам ямар байх нь Нээлттэй төсвийн индекст эзлэх засгийн газрын байрт нөлөө үзүүлээгүй байна. Тухайлбал, төр засаг баримт бичгээ түгээхдээ интернэтийг ашигласан эсэх нь Нээлттэй төсвийн индекс-т авсан оноонд нөлөө үзүүлээгүй байна. Зөвхөн цаасан дээр хэвлэсэн байдлаар баримт бичгийг түгээдэг улс орнууд ижил нөхцөлтэй байсан. Гэхдээ интернэтийн хүртээмж өсч байгаа чиг хандлагыг ажиглах зорилгоор судалгааны нэгдүгээр хэсэгт багтсан хүснэгтүүдэд зохих өгөгдөл мэдээллийг уг асуулгад цуглуулж нэгтгэсэн юм (энэ нь Нээлттэй төсвийн индексийг тооцоход ашиглагдаагүй).

## Нээлттэй төсвийн индексийг тооцох нь

Нээлттэй төсвийн индекс нь Нээлттэй төсвийн асуулгад орсон нийтэд ил тод мэдээлэлтэй холбоотой 91 асуултад өгсөн хариултын дунджаас бүрдсэн. Энэхүү оноо нь төсвийн жилийн турш төр засгаас гаргах ёстой төсвийн долоон гол баримт бичигт агуулагдсан төсвийн олон нийтэд ил мэдээллийн чанарыг тусгаж байгаа.

Нээлттэй төсвийн асуулгын ихэнх асуултад судлаач боломжит таван хариултаас сонгож хариулах ёстой байсан. “a” болон “b” үсэгт тохирох хариулт тухайн асуултын сэдвийн хүрээнд сайн туршлагыг илэрхийлэх нөхцөл байдлыг харуулж байгаа гэж үзнэ. “c” болон “d” хариулт нь тааруухан туршлага байгааг илэрхийлнэ. “a” хариулт нь тодорхой стандартыг бүрэн биелүүлж байна гэж үзэх бол “d” хариулт нь уг стандарт шаардлага огт хангагдаагүйг илэрхийлнэ. Тав дахь хариулт буюу “e” нь уг асуулт хамааралгүйг илэрхийлнэ. Ишлэл татах, зохих газар нь нэмэлт санал дүгнэлт өгөхийг судлаачдаас хүссэн нь асуулгын агуулгыг улам бүр баяжуулсан юм.

Хариултуудыг нэгтгэх зорилгоор “a” хариултад 100 хувь буюу оноо, “b” хариултад 67 оноо, “c” хариултад 33 оноо, “d” хариултад 0 оноо өгсөн. Асуултад “e” хариултыг өгсөн бол уг асуултыг Нээлттэй төсвийн индексээс хасч тооцсон болно.

Зарим асуултад “a”, ”b” болон “c” (хамааралгүй) гэсэн гурван хувилбараас сонгон хариулах боломжтой. Эдгээр асуултын хувьд “a” хариултад 100 хувь, “b” хариултад 0 оноо өгсөн. “c” хариултыг өгсөн тохиолдолд тухайн улсын хувьд Нээлттэй төсвийн индексийг тооцоход уг асуултыг харгалзахгүй байхаар тогтжээ.

Индекс дэх улс орны гүйцэтгэлийг үзүүлэх зорилгоор 81-100 хувийн оноо авсан улс орны засгийн газрыг “иргэдээ иж бүрэн мэдээллээр хангадаг”, 61-80 хувь авсан улс орны засгийн газрыг “иргэдээ боломжийн хэмжээний мэдээллээр хангадаг, 41-60 оноо авсан улс орны засгийн газрыг “иргэдээ зарим мэдээллээр хангадаг”, 21-40 оноо авсан улс орны засгийн газрыг “иргэдээ бага хэмжээний мэдээллээр хангадаг” гэж ангилсан. Эцэст нь 20-иос доош оноо авсан улс орны засгийн газар нь “иргэдээ хангалтгүй хэмжээний мэдээллээр хангадаг буюу мэдээллээр огт хангадаггүй” гэж үзсэн.

### Нээлттэй төсвийн индекст хамруулан тооцсон асуултууд:

| | |
|---|---|
| Төсвийн өмнөх (хүрээний) мэдэгдэл | Асуулт 72, 73, 74 |
| Гүйцэтгэх засаглалын төсвийн санал (төсөл) | Асуулт 1-55, 67, 68, 69 |
| Иргэдэд зориулсан төсөв | Асуулт 61 |
| Жилийн явцын тайлан | Асуулт 84-91 |
| Хагас жилийн тойм | Асуулт 93-96 |
| Жилийн эцсийн тайлан | Асуулт 102-111 |
| Аудиторын тайлан | Асуулт 112-114, 116, 120-122 |

# II. НЭЭЛТТЭЙ ТӨСВИЙН ИНДЕКС

Нээлттэй төсвийн индекс нь тухайн улсын төсвийн баримт бичигт тусгагдсан төсвийн мэдээлэлд төвлөрсөн нь эдгээр баримт бичгийн чухал ач холбогдолтой болохыг илтгэнэ. Тухайн улсын төсвийн баримт бичиг нь засгийн газрын төсөв, санхүүгийн үйл ажиллагааны талаар олон нийтэд ил тайлагнах явдлын хувьд хамгийн сайн, тодорхой эх сурвалж болдог. Засгийн газрын төсөв санхүүгийн байдлыг тухайн төсвийн жилийн эхэнд болон жилийн туршид ямар байгааг иж бүрэн байдлаар олон нийтэд хүргэн танилцуулах зорилгоор эдийн засаг, санхүүгийн өргөн хүрээний мэдээллийг тухайн улсын төсвийн баримт бичигт нэгтгэн тусгасан байх ёстой. Хариуцлага хүлээх тогтолцоо бүхий төсөвлөлтийг нэвтрүүлэхэд мэдээллийн хүртээмж дангаараа хангалтгүй ч иргэдийн хүсэл эрмэлзлийг илэрхийлсэн төсөвлөлтийн зайлшгүй шаардлагатай, магадгүй хангалттай нөхцөл нь мөн.

Уг индекс нь төсвийн жилийн туршид олон нийт авах боломжтой байх учиртай төсвийн долоон гол баримт бичиг дэх мэдээллийг шинжилсэн. Эдгээр баримт бичигт агуулагдсан мэдээллийг засгийн газрын бодлогод дүн шинжилгээ хийж, түүнийг мэдэх сонирхолтой хүмүүст ашиглаж болохуйц тохиромжтой хэлбэрээр танилцуулсан, эдгээр баримт бичгүүдэд асуудлыг хэр иж бүрэн авч үзсэн, баримт бичгүүдийг цаг хугацааны хувьд оновчтой үед нь гаргасан эсэхэд үнэлгээ өгсөн болно. Төсвийн баримт бичиг нь төр засаг өөрийн тулгамдсан зорилтуудаа ил болгох, иргэд эдгээр зорилтуудыг өөрсдийн хүсэл эрмэлзэлтэйгээ харьцуулан дүгнэх боломжийг олгодог зүйл юм. Иймд учраас Нээлттэй төсвийн индексийн ерөнхий дүн нь санаа ихээхэн зовоож байна.

Төр засагтай хариуцлага тооцоход шаардагдах төсвийн иж бүрэн мэдээллийг төсвийн жилийн турш цөөн тооны улс орон хангадаг болохыг Нээлттэй төсвийн индексийн дүн харуулж байна. Судалгаанд хамрагдсан 59 улс орны зөвхөн зургаа нь буюу Франц, Шинэ Зеланд, Словени, Өмнөд Африк, Их Британи болон АНУ л төсвийн баримт бичигтээ төсвийн иж бүрэн мэдээллийг хангадаг байна.

Үлдсэн 53 улс нь нэг бол төсвийн долоон гол баримт бичгийн аль нэгийг, хэд хэдийг нь гаргадаггүй, эсвэл эдгээр баримт бичигт тусгадаг мэдээлэл нь бүрэн бус байна. Нээлттэй төсвийн индекст хамрагдсан улс орны ихэнх нь буюу арван улсын ес нь нийтийн өмч хөрөнгийг удирдах, ашиглахтай холбогдуулан төр засагтай хариуцлага тооцох бололцоог иргэдэд олгохуйц хэмжээний мэдээллээр хангаж чадахгүй байна.

## Хүснэгт 1. Нээлттэй төсвийн индекс - 2006

| | | | | |
|---|---|---|---|---|
| Иргэдээ иж бүрэн мэдээллээр хангадаг | АНУ | Их Британи | Словени | |
| | Франц | Өмнөд Африк | Шинэ Зеланд | |
| Иргэдээ боломжийн хэмжээний мэдээллээр хангадаг | Ботсвана | Өмнөд Солонгос | Румын | |
| | Бразил | Перу | Чех | |
| | Норвеги | Польш | Швед | |
| Иргэдээ зарим мэдээллээр хангадаг | Болгар | Кени | ОХУ | Хорвати |
| | Гана | Колумб | Пакистан | Шри Ланка |
| | Гватемал | Коста-Рик | Папуа Шинэ Гвиней | Энэтхэг |
| | Индонези | Малави | Танзани | |
| | Иордан | Мексик | Турк | |
| | Казахстан | Намиб | Филиппин | |
| Иргэдээ бага мэдээллээр хангадаг | Албани | Бангладеш | Замби | Эл Сальвадор |
| | Алжир | Гүрж | Непал | |
| | Аргентин | Гондурас | Уганд | |
| | Азербайжан | Камерун | Эквадор | |
| Иргэдээ хангалтгүй хэмжээний мэдээллээр хангадаг, эсвэл огт хангадаггүй | Ангол | Вьетнам | Монгол | Чад |
| | Болив | Египт | Нигери | |
| | Буркина Фасо | Марокко | Никарагуа | |

Боломжийн хэмжээний мэдээллээр хангадаг улс орны ангилалд нийт 9 улс багтаж байгаа ч тэдгээрийн авсан оноонд нэг буюу түүнээс дээш тооны нэн чухал баримт бичгийг гаргадаггүй нь нөлөөлж байна. Энэ ангилалд багтсан улсын жишээ нь Ботсвана юм. Төсвийн хүрээний мэдэгдлийг олон нийтэд зориулан нийтэлдэггүй нь уг улсын оноонд сөргөөр нөлөөлжээ. Мөн Швед улсын хувьд төсвийн бүх зарцуулалтыг агуулсан хагас жилийн иж бүрэн тоймыг нийтэлдэггүй нь ерөнхийдөө сайн гүйцэтгэлийг нь сулруулж байна.

Бусад засгийн газрын хувьд уг индекст тааруухан оноо авсан нь хууль тогтоох байгууллагад өргөн барьдаг жилийн төсвийн төсөлд агуулсан мэдээлэл хангалтгүй байгаатай холбоотой.

“Зарим мэдээллээр хангадаг ангилалд багтсан олон улс орны хувьд байдал ийм байсан. Ийм улсын тоонд Иордан, Казахстан, Кени зэрэг орно. Энэ ангилалд орсон бусад улс орны хувьд жилийн явцын болон жилийн эцсийн тайлан гаргадаггүй байна.

Хамгийн ноцтой нь нийт 23 улс орон төсвийн талаар иргэдээ бага хэмжээний мэдээллээр хангадаг, мэдээлэл огт хангадаггүй гэсэн сүүлийн хоёр ангилалд багтаж байна. Улсын төсвийн талаар багахан ч мэдээллээр хангахгүй байх нь төсвийн нээлттэй байдлын хувьд тавигдах наад захын шаардлагыг ч биелүүлж чадахгүй байгааг илтгэнэ.

Эдгээр улс орноос арав нь буюу Ангол, Болив, Буркина Фасо, Чад, Египет, Монгол, Марокко, Никарагуа, Нигери, Вьетнам улсууд сүүлчийн ангилалд багтсан байна. Энэ улс орнууд нь төсвийн баримт бичигтээ хангалтгүй хэмжээний мэдээллийг тусгадаг буюу огт мэдээллээр хангадаггүйгээс төсвийн үйл явц нь хаалттай шинж чанартай, олон нийтийн өмнө хариуцлага хүлээх нь ихээхэн дутагдалтай байгааг илтгэх ихээхэн ноцтой асуудал юм. Эдгээр улс оронд гүйцэтгэх засаглал төсвийн төслөө хууль тогтоох байгууллагаар батлагдахын өмнө нь олон нийтэд хүргэдэггүй, эсвэл баримт бичигтээ туйлын хангалтгүй мэдээлэл тусгадаг байна.

Индексээс харахад ил тод байдлыг хангах сайн туршлага хөгжингүй, хөгжиж буй улс орнуудад аль алинд нь байна. Словени, Өмнөд Африк хоёр харьцангуй богино хугацаанд төсвийн ил тод байдлаа эрс сайжруулсан юм. Эдгээр улсуудад төвлөрсөн төлөвлөлт, арьс өнгөөр ялгаварлан гадуурхах дэглэмийн хаалттай мэдээллийн тогтолцооноос төсвийн баримт бичгийн нээлттэй, тэргүүн туршлагыг мөрдөн хэрэгжүүлэх хүртэл ердөө аравхан жил шаардагдсан байна.

Гэсэн хэдий ч судалгааны гол үр дүн болох ихэнх улс орнууд төсвийн ил тод байдлын хувьд тун тааруухан гүйцэтгэлтэй байгаа нь анхаарал татах асуудал болж байна. Судалгаанд хамрагдсан 59 улс орноос 23 нь иргэдээ төсвийн багахан ч мэдээллээр хангахгүй байна. Ийм улс орны тоонд олон жилийн турш хандивлагчдын ихээхэн тусламж авч байгаа, олон улсын хандивлагчид болон хөрөнгө оруулагчдын дунд нэр хүндтэй хэд хэдэн улс орон ч байна. Хангалтгүй дүн үзүүлсэн улсуудын жагсаалтад Африк, Ази, Латин Америк, Ойрхи Дорнодын бага болон дунд орлоготой улс орнууд багтжээ.

Нээлттэй төсвийн индекс нь улс тус бүрийн төсвийн мэдээлэл олон нийтэд ил тод байдлын тухайн үеийн дүр зургийг харуулж байна. Эдгээр улс оронд мэдээллийн орчин сайжирч, эсвэл муудаж байгааг уг индекс харуулж чадахгүй юм. ОУТТ нь ийм чиг хандлагыг ирээдүйн судалгаандаа тусгана гэж итгэж байна. Гэхдээ тодорхой байгаа зүйл бол тухайн улсын төсвийн ил тод байдлын түвшинд иргэдийнхээ өмнө хариуцлага хүлээх төр засгийн хүсэл эрмэлзлээс ихээхэн хамааралтай байгаа бөгөөд мэдээллийг бэлтгэн боловсруулах чадвар дутагдах нь хамгийн гол саад биш юм байна. Нээлттэй төсвийн индекст хамгийн тааруу дүн үзүүлсэн улс орон чадавхитай холбоотой саад бэрхшээлийг шалтаглах боломжгүй бөгөөд богино хугацаанд багахан нөөц хөрөнгө зарцуулсанаар ил тод байдлаа ихээхэн сайжруулах боломжтой юм.

# III. ТӨСВИЙН ГОЛ БАРИМТ БИЧГИЙГ НЯГТЛАН ҮЗЭХ НЬ

Төр засгаас бэлтгэн гаргах ёстой төсвийн долоон гол баримт бичгийг илүү нарийвчлан нягтлан үзвэл олон нийтэд түгээдэг мэдээллийн ихэнх хэсгийг засгийн газар жилийн төсвийн санал буюу төсвийн төслийн хүрээнд өгдөгийг ажиглаж болно. Харин төсвийг хэрэгжүүлэх шатанд ихэнх улс оронд мэдээлэл хомс болдог байна. Төсвийг хэрэгжүүлэх үе шатанд ийнхүү мэдээллийн дутагдал үүсдэг нь гүйцэтгэх засаглалын зарцуулах шийдвэр, орлого хураалт болон зөвшөөрөгдсөн өр зээлийн хэмжээнд зохицож байгаа зэрэгтэй холбоотойгоор хариуцлага хүлээх байдал ямар байгаа нь анхаарал татаж байна. Мөн судалгааны дүнгээс харахад аудитын болон хууль тогтоогч байгууллагын оролцоог нэмэгдүүлснээр хариуцлага тооцох явдлыг сайжруулах ихээхэн боломж байна.

## Боловсруулсан мэдээллийг түгээхгүй байх нь

Засгийн газраас олон нийтэд ил болгодоггүй төсвийн ихэнх баримт бичгийг дотоод хэрэгцээнд, эсвэл хандивлагчдад зориулан бэлтгэдэг нь судалгааны нэг гайхмаар үр дүн байлаа. Судалгаанд хамрагдсан 59 улс оронд нийтэд ил болгоогүй төсвийн долоон гол баримт бичгийн чухам хэд нь бэлтгэн боловсруулагддаг талаар төр засгийн албан тушаалтнуудаас ярилцлага авчээ.

Жишээлбэл, доорхи хүснэгтээс харахад 23 улс оронд төсвийн хүрээний мэдэгдлээр дамжуулан нийтэд ил болгох ёстой мэдээллийг засгийн газраас боловсруулан бэлтгэдэг ч нийтэд ил тод мэдээлэхгүй байхаар шийджээ. Олон тооны буюу 13 улс оронд аудитын дээд байгууллага нь аудитын тайлан бэлтгэдэг ч олон нийтийн сонорт бас л хүргэдэггүй нь анхаарал татаж байна.

Төсвийн долоон гол баримт бичгийн нэгээр буюу хэд хэдээр дамжуулан олон нийтэд хүргэх төсвийн мэдээллийг нийт улс орны хагасаас илүүд нь (32) бэлтгэдэг байна. Үүнээс үзэхэд нэгэнт бэлтгэн боловсруулсан мэдээллийг засгийн газар нь олон нийтэд ил болгосноор тухайн улс орнууд ил тод байдлаа ихээхэн нэмэгдүүлэх боломжтой юм. Эндээс үзэхэд

мэдээллийг бэлтгэн боловсруулах чадавхигүй, хөрөнгөгүйдээ бус өөрсдийн сонголтоор л засгийн газар олон нийтэд мэдээллийг ил болгож хүргэдэггүй байна.

**Хүснэгт 2. Төсвийн гол баримт бичгүүд**

Судалгаанд хамрагдсан 59 улс орноос




## Гүйцэтгэх засаглалын төсвийн санал (төсвийн төсөл)

Төсвийн жилийн туршид бэлтгэгддэг төсвийн хамгийн чухал баримт бичгийн нэг бол гүйцэтгэх засаглалын жилийн төсвийн санал юм. Энэ баримт бичиг нь засгийн газраас ирэх жилд биелүүлэхийг зорьсон бодлогын тунхаглал юм. Хууль тогтоох байгууллагаас гүйцэтгэх засаглалын төсвийг батлах нь засгийн газрын сонгосон гол чиглэлийн асуудлуудыг хүлээн зөвшөөрч байгаа хэрэг билээ. Хариуцлага тооцолтыг хангахад зайлшгүй шаардлагатай иж бүрэн мэдээллийг 59 улс орны зөвхөн тав нь л төсвийн саналдаа тусган иргэддээ хангадаг гэсэн судалгааны үр дүн санаа ноцтой зовоож байна. Энэ таван улс нь Франц, Шинэ Зеланд, Өмнөд Африк, Их Британи болон АНУ юм.

Тааруухан оноо авсан улс орнуудын санал нь (эсвэл саналыг бүрдүүлж буй хэд хэдэн багц баримт бичиг) засгийн газрын ирэх жилийн болон цаашдын хэд хэдэн жилийн төсөв санхүүгийн байдлыг иж бүрэн харуулж чадахгүй байна. Жишээлбэл, зарим улс оронд эдгээр баримт бичигт засгийн газрын бодлогын зорилгуудыг тусгаагүй, эсвэл эдгээр зорилгод хүрэхэд шаардагдах зарцуулалт ямар болохыг заагаагүй байна. Зарим засгийн газар хүлээгдэж буй орлого, татварын хөнгөлөлт чөлөөлөлтийн дүн, засгийн газрын бусад түвшинд хийгдэх шилжүүлэг, тусламжийн зориулалт, төрийн өмчит компани зэрэг нэгжид өгөх татаас, авах зээл, хийх төлбөр хугацаа хэтэрсэн байдал, эсвэл зээлийн баталгааны

нарийвчилсан мэдээллийг ил болгоогүй байна. Эцэст нь, санхүүгийн болон санхүүгийн бус эд хөрөнгө, тэтгэврийн болон нийгмийн хамгааллын бусад хөтөлбөрүүдтэй холбоотой өнөөгийн гүйцэтгэл, ирээдүйн өр төлбөр, үүрэг хариуцлага, эрсдэлтэй холбоотой мэдээллийг зарим засгийн газар ил тодоор олон нийтэд тайлагнахгүй байгаа нь нийтлэг ажиглагдаж байна.

### Хүснэгт 3. Гүйцэтгэх засаглалын төсвийн санал (төсвийн төсөл)

Олон нийт хүртэх боломжтой мэдээллийн хэмжээ, улс орноор

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Иргэдээ иж бүрэн мэдээллээр хангадаг | АНУ<br>Их Британи | Өмнөд Африк<br>Франц | Шинэ Зеланд | | |
